



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/09

Чингис хот

“Өсвөр үеийн шигшээ баг”-ийн спортын  
нэр төрлийг тогтоож, зардал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын “а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.20, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол, 2017 оны “Журам батлах тухай” 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Өсвөр үеийн шигшээ баг”-ийн тамирчдын 2021 оны төсвийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар, дасгалжуулагчийн цалингийн төсвийг хоёрдугаар хавсралтаар, спортын нэр төрөл, тоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 50530200 /тавин сая таван зуун гучин мянга хоёр зуун/ төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

3. Өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар ханган, хичээл сургуулилт, ажлын үр дүнг улирал бүр тооцон хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллахыг Биеийн тамир, спортын газар /Г.Нэргүйбаатар/-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дарга /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Ц.ИДЭРБАТ

231010039





Аймгийн Засаг даргын 2021 оны  
...01 дугаар сарын... өдрийн .../09...  
дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



"Өсвөр үеийн шигшээ баг"-ийн спортын нэр төрөл, тоо

1. Бадминтон
2. Буудлага
3. Волейбол
4. Даам
5. Жүдо бөх
6. Сагсан бөмбөг
7. Самбо бөх
8. Чөлөөт бөх
9. Үндэсний бөх
10. Шатар
11. Хөнгөн атлетик
12. Хүндийн өргөлт
13. Хоккей